ДОРНОД АЙМАГ
БАЯНТҮМЭН СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 08 сарын 05 өдөр Дугаар 13/04 Цагаан дэрс

Байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөл байгуулахыг дэмжих тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт, 3 дугаар багийн иргэдийн Нийтийн Хурлын 2026 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн 05 дугаар тогтоол, 4 дүгээр багийн иргэдийн Нийтийн Хурлын 2026 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн 05 дугаар тогтоолыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1.Баянтүмэн сумын Өлзийт багийн нутаг дэвсгэрт багийн иргэдийн бүрэлдэхүүнтэй Байгалийн нөөцийн хамтын менежментийн “Шар өндөр”, Хотонт багийн нутаг дэвсгэрт багийн иргэдийн бүрэлдэхүүнтэй Байгалийн нөөцийн хамтын менежментийн “Шаазан нуур” нөхөрлөлийг тус тус үүсгэн байгуулахыг дэмжсүгэй.

2.“Шар өндөр”, “Шаазан нуур” нөхөрлөлийн хариуцан хамгаалах газар нутгийн хэмжээ, нэршлийг хавсралтаар баталсугай.

3.Холбогдох хууль тогтоомжийн дагуу үйл ажиллагаа явуулж, үр дүнг Засаг даргад тайлагнахыг нөхөрлөлийн ахлагч нарт, гэрээ байгуулж, менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, үр дүнг тайлагнахыг сумын Засаг дарга (П.Гунгаацэрэн)-д тус тус үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА Ж.БАТЧУЛУУН